

Одрын санхүү

2010.01.14

№: 010 (3400)

НҮБ Монгол Улсын Хүний Эрхийн Төлөв Байдлыг Дүгнэн Хэлэлцэнэ

2010 оны арваннэгдүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг дүгнэн хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан төрийн бус байгууллагууд зөвлөлджээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 онд НҮБ-ын Хүний эрхийн комиссыг Хүний эрхийн зөвлөл болгон өөрчилж, дэлхийн бүх хүмүүсийн тусын тулд НҮБ-ын гишүүн 192 улсын хүний эрхийн төлөв байдлыг Хүний эрхийн зөвлөлд дөрвөн жил тутам илтгэн хэлэлцүүлж байх шинэ механизм бий болгосон байна.

Монгол Улсын Засгийн газар хүний эрхийг хангах, хамгаалах талаар олон улсын болон иргэдийнхээ өмнө хүлэсэн үүрэг, амлалтаа хэрхэн хэрэгжүүлж байгааг 2010 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүд дүгнэн хэлэлцэх гэж байна. Уг дүгнэлт хэлэлцүүлэгт Монгол Улсын Засгийн газар үндэсний тайлан бэлтгэн оролцохоос гадна манай улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, төрийн бус байгууллагууд тайлан илтгэл бэлтгэн оруулах боломжтой гэнэ.

Иймд Хүний эрх хөгжил төв болон

“Глоб Интернэшнл” ТББ-ууд хамтран Хүний эрх хөгжлийн төлөөх Азийн Форум хэмээх бүсийн хүний эрхийн байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулсан “Хүний эрхийн зөвлөлийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт төрийн бус байгууллагууд бэлтгэх нь” сургалт, зөвлөгөөнд хүний эрхийн янз бүрийн чиглэлээр ажилладаг 40 гаруй төрийн бус байгууллага оролцсон байна.

Зөвлөгөөнөөс хүний эрхийн ээлжит үзлэгт бэлтгэх Монголын төрийн бус байгууллагуудын форум байгуулж, дараахь асуудлаар хүний эрхийн илтгэл бэлтгэн Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт илгээхээр тогтлоо. Үүнд, Форумын нэгдсэн илтгэл буюу Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг нэгтгэн дүгнэсэн илтгэл

·2008 оны долдугаар сарын 1-ний үйл явдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн талаарх илтгэл

- Байгаль орчин, уул уурхай
- Хүнсний эрх
- Цөөнхийн хүний эрхийн байдал
- Шилжин суурьшигчдын хүний эрхийн байдал

·Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт

Мөн Хүний эрхийн төлөв байдлын

ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн үйл явцын бүхий л үе шатанд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө, цогц стратегийг хэлэлцэж, Австралийн Засгийн газар болон Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр тогтлоо.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт бэлтгэх төрийн бус байгууллагуудын форум нь нээлттэй ажиллах бөгөөд хүний эрхийн асуудалд санаа зовнин ажилладаг төрийн бус байгууллага, иргэдийг Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт бэлтгэх ажилд идэвхтэй оролцож хамтран ажиллахыг урьж байна.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан журамд Хүний эрхийн ээлжит үзлэгт илгээх үндэсний илтгэлийг үндэсний хэмжээнд холбогдох бүх талуудтай өргөнөөр хэлэлцсэн үндсэн дээр бэлтгэхийг гишүүн улсуудын Засгийн газруудад зөвлөсөн байдгийг сануулж, Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын үндэсний илтгэлийг бэлтгэх бүхий л үе шатанд иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулж эхлэхийг Монгол Улсын Засгийн газарт уриалж байна.

Л.МӨНХТӨР